ПРЕМИУМ НЭКСУС ХК

2026 ОНЫ 3-Р УЛИРЛЫН САНХҮҮ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ИРЭЭДҮЙГ ЧИГЛЭСЭН МЭДЭГДЛИЙН ТАЛААРХ АНХААРУУЛГА

Премиум Нэксус ХК-ийн энэхүү тайланд “ирээдүйг чиглэсэн” зарим мэдэгдэл агуулагдсан болно. Тухайлбал, тус тайланд “бид таамаглаж байна, бид тооцоолж байна, бид зорьж байна, бид төлөвлөж байна” гэх мэт хэллэг, тэдгээртэй ойролцоо утгатай үг, мөн ирээдүй цагийг илэрхийлэх үгс ашиглагдсан болно. Ирээдүйг чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлын баталгаа биш бөгөөд бидний таамагласан нөхцөл байдал биелэхгүй байх магадлалтай ба тэдгээр таамаглалуудад хэт найдах нь учир дутагдалтайг анхаарна уу.


Компанийн бизнесийн үйл ажиллагааны бодит үр дүн нь эрсдэл, тодорхойгүй байдал зэрэг хүчин зүйлс, түүнчлэн эдгээрээр хязгаарлагдахгүй бусад шалтгааны улмаас энэхүү тайланд тусгасан ирээдүйг чиглэсэн мэдэгдлээс материаллаг зөрүүтэй байж болно. Тиймээс, эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлыг харгалзан үзэж ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг шууд утгаар нь бодитоор биелнэ хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Мөн, компанийн зүгээс шинэ мэдээ мэдээлэл болон ирээдүйд гарах ялгаатай үр дүн эсвэл аливаа бусад шаардлагын улмаас энэхүү тайланд тусгагдсан ирээдүйд чиглэсэн таамаглалуудыг шинэчлэх эсвэл засварлах аливаа үүрэггүй болохыг мэдэгдэж байна.

Агуулга

- Компанийн тухай 03
- CU Конвиниенс дэлгүүр 06
- 2026 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд 09
- Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга 20
- Хувьцааны ханшийн хөдөлгөөн 23


Компанийн тухай

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН УДИРДЛАГА



Компанийн тухай

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН БИЗНЕСИЙН БҮТЭЦ



Компанийн тухай

Премиум Нэксус ЭКОСИСТЕМ ба түүний давуу талууд

Олон улсын стандартад нийцсэн хоол

Хоолны бүтээгдэхүүний гинжин хэлхээний бүх үе шатанд олон улсын стандарт, шилдэг туршлагад суурилсан хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтыг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд үндэсний үйлдвэрлэгчид HACCP баталгаажуулалтад хамрагдаж, салбарын стандартыг шинэ түвшинд хүргэн, зах зээлд манлайлах боломж бүрдэж байна.

Байгал орчин, нийгэм, засаглалын өндөр стандартыг өргөн хүрээнд нэвтрүүлэх

CU сүлжээ дэлгүүрийн ханган нийлүүлэгчид, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэгчид энэхүү экосистемд нэгдсэнээр, Премиум Нэксус ХК-ийн олон улсын жишигт нийцсэн БОНЗ-ын практикийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Логистик болон нэгдсэн түгээлтийн үр ашиг

Монголын дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд логистикийн зардал бүтээгдэхүүний нийт өртөгт эзэлж буй хувиараа дэлхийн дунджаас 2-3 дахин өндөр байдаг. Премиум Нэксус нь логистикийн дэд бүтцийн сайжруулалт хийснээр дээрх үр ашиггүй байдлыг бууруулах болно.

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж

CU сүлжээ дэлгүүр үйлдвэрлэгчидтэйгээ хамтран бүтээгдэхүүн хөгжүүлснээр хэрэглэгчдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж бүрдэнэ. Ингэснээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэх, үнэнч хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

Хөрөнгө оруулагчдын нэгдмэл ашиг сонирхол

CU сүлжээ дэлгүүрийг түшсэн, түүнтэй хамаарал бүхий бизнесүүдийг нэг дор нэгтгэснээр тэдгээр бизнесүүд хамтын хүчээр үлэмж үнэ цэнийг бий болгох боломжтой. Ингэснээр хөрөнгө оруулагчид энэхүү синергээс бий болох бүх боломжийг хүртэх нөхцөл бүрдэнэ.

Ажилтнуудын өсөж дэвших боломж, сэтгэл ханамж

Монголын томоохон хөрөнгө оруулалтын компанийн нэг хэсэг болж ажиллах, групп компани дотроо өсөж хөгжих, Премиум туршлагаас суралцах зэрэг боломжууд ажилтнуудад нээлттэй болно.

CU Конвиниенс дэлгүүр

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Хамгийн их сүлжээ дэлгүүртэй

2025 оны Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгж 7-р байр

Тэргүүлэгч жижиглэн худалдааны компани

Зах зээлийн үнэлгээ: 338.8 тэрбум төгрөг



Нэгтгэсэн нийт цэвэр борлуулалт
725+ тэрбум төгрөг



Өдрийн дундаж хэрэглэгч
220,000+



Дэлгүүрийн ажилтан
~4,750



Дэлгүүрийн тоо
651



Хамтрагч байгууллага
500+



Ажиллагсад
~5,170




Хувьцаа эзэмшигчид
10,861

CU Конвиниенс дэлгүүр

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Үйлчлүүлэгчдийн тоо (сая)




Дэлгүүрийн тоо

	2025Q3	2026Q3	Өссөн дүн
УБ	425	534	109
Орон нутаг	90	117	27
Нийт	**515**	**651**	**136**

Ажиллагсдын тоо



Дэлгүүрийн тоо



**Ажилласан хүний тоо буюу тайлант хугацаанд нийгмийн даатгал төлөгчдийн тоо, давхардаагүй дүнгээр.*

CU Конвиниенс дэлгүүр

CU ХАРЬЦУУЛСАН БОЛОН НИЙТ ДЭЛГҮҮРИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

2025 болон 2026 оны 3 дугаар улиралд бүтэн үйл ажиллагаа явуулсан 515 дэлгүүрийн гүйцэтгэлийг харьцуулсан болно. Эдгээр дэлгүүрийн 2025 болон 2026 оны өдрийн дундаж үзүүлэлтүүдийг харьцуулахад үйлчлүүлэгчдийн тоо 0.98%-иар, өдрийн дундаж борлуулалт 3.02%-иар, худалдан авалтын дундаж сагсны дүн 2.02%-иар тус тус өссөн байна.

Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

	2025Q3 → 2026Q3
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	3.02%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	0.98%
Сагсны үнийн өсөлт	2.02%

Харьцуулсан дэлгүүрийн тоо: 515

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

Харин уг үзүүлэлтийг бүх дэлгүүрийн хэмжээнд буюу 2025 оны 3-р улирлын байдлаар 528 дэлгүүр (хаагдсан дэлгүүрийг хамруулан тооцсон), 2026 оны 3-р улиралд ажилласан 651 дэлгүүрийн хувьд тооцож үзэхэд өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тоо 3.19%-иар буурч, дундаж сагсны дүн 2.48%-иар өссөнөөр өдрийн дундаж борлуулалт 0.79%-иар буурчээ.

Шинээр нээгдсэн дэлгүүр тогтвортой борлуулалтад хүрэхэд хэдэн сар шаардагддаг. Шинэ дэлгүүр олноор нэмэгдэх үед эдгээр нь системийн дундаж үзүүлэлтийг түр доошлуулдаг тул бодит өсөлтийг харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэлээр хэмждэг.

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл


	2025Q3 → 2026Q3
Өдрийн дундаж борлуулалт	-0.79%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тоо	-3.19%
Сагсны үнэ	2.48%

Нийт дэлгүүрийн тоо: 528 → 651

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР

Онцлох үйл явдлууд

- 117 шинэ дэлгүүр нээж, 11 дэлгүүр хааснаар нийт 651 дэлгүүртэй болсон.
- Улаанбаатар хотод 534, орон нутагт 117 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.
- Нийт 16 аймагт хүрээгээ тэлсэн.



	2025	2026Q3
CU дэлгүүрийн тоо	545	651

CU Конвиниенс дэлгүүр нь Монгол орныг зорин ирэх жуулчид болон нутгийн иргэдэд олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг хүргэхээр Улаанбаатар хотоос алслагдмал аймгууд болох Хөвсгөл, Баянхонгор, Дорнод аймгуудад шинээр салбар дэлгүүрээ нээн Монгол орны 16 аймагт үйл ажиллагаа явуулж байна. CU Конвиниенс дэлгүүр нь үйл ажиллагаагаа Монгол орон даяар амжилттай тэлснээр бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, шинээр ажлын байрууд бий болгохын зэрэгцээ орон нутгийн иргэд, байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж, хөгжил дэвшлийг хамтдаа бүтээх боломж бүрдэж байна.

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР

ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН



-GET MORNING-

Өглөөний цайны сонголт илүү их боллоо. Ингэснээр хэрэглэгч өдрийн бүх хэрэгцээгээ нэг цэгээс авах боломжийг бүрдүүлж, амьдралыг илүү хялбар, тухтай болгож байна.



-REAL SMOOTHIE-

Жинхэнэ жимсээрээ, нэмэлт орц, нөөшлөгч бодисгүй смүүти илүү олон салбарт гардаг боллоо. **100 салбараас** өдөр бүрийн ногоо, жимс, витамины хэрэгцээг нөхөх боломжтой.



-CHOICE FOR U-

Хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлсэн амт чанарыг хадгалсан, бүрэн боловсруулж гүн хөлдөөсөн, шууд халаагаад идэхэд бэлэн хоолны сонголтууд нэмэгдэв.

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР


ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН



-Dubai Chewy Cookie-

Солонгост төдийгүй олон улсын зах зээлд тренд болоод байгаа Дубай шоколадтай, зөөлөн жигнэмэгийг импортлон зөвхөн CU-гээр санал болгож эхлэв.





-NonFood Essentials-

Дотоодын нийлүүлэгчидтэй хамтран нэг удаагийн хэрэглээнд зориулсан мини савлагаатай багц бүтээгдэхүүнийг хөгжүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээг илүү хялбарчилж, хүртээмжийг нэмэгдүүлсээр байна.


Хэрэглэгчдийн яаралтай хэрэгцээг хангах зорилгоор 3,000 mAh багтаамжтай зөөврийн цэнэглэгчийг бүтээгдэхүүний нэр төрөлд шинээр нэвтрүүллээ.

2026 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

CU БРЭНДИЙН НЭРИЙН УС
















CU брэнд нь нэрийн бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлэн Монос Фүүдс ХХК-тай хамтран CU Pure Water (pH 6.5) усыг хөгжүүлж, 2026 оны 07-р сарын 10-ны өдөр зах зээлд шинээр нэвтрүүллээ. Энэхүү ус нь хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд зориулсан зөөлөн амттайгаас гадна БОНЗ-ын бодлогын хүрээнд "tethered cap" буюу савнаасаа салдаггүй тагны шийдлийг нэвтрүүлж, хуванцар хаягдлыг бууруулах хэрэглээг дэмжсэнээрээ онцлогтой.


CU - САЙХАН ХООЛЛООРОЙ





Хэрэглэгчдэдээ илүү ойр, илүү хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2026 оны 08-р сараас эхлэн “Сайхан хооллоорой” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөр нь хүн бүрийг өдөр тутамдаа эрүүл, чанартай, амттай хоолоор хооллох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Компани өглөө, өдөр, оройн аль ч цагт хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн, стандартын шаардлага хангасан хоолыг үйлдвэрлэн цаг алдалгүй хүргэхийг зорьж байна. Хэрэглэгчийн итгэлийг эрхэмлэн, чанарын хяналтыг үйлдвэрлэлийн бүх шатанд нэгэн жигд хэрэгжүүлж, бүтээгдэхүүний төрөл, сонголтыг тогтмол сайжруулж байна. Хөтөлбөрийн хүрээнд CU брэнд нь чанар, стандартын өндөр түвшнийг хадгалан, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахад цаашид ч тууштай ажиллах болно.

CU-SELF CHECKOUT ӨӨРТӨӨ ҮЙЛЧЛЭХ ПОС НЭВТЭРЛЭЭ





2026 оны 09-р сараас эхлэн CU-гийн 35 салбарт өөртөө үйлчлэх ПОС-ын системийг нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэллээ. Худалдан авагчид дараалал хүлээлгүйгээр тооцоогоо өөрсдөө хийх боломжтой болсноор оргил цагаар үүсэх дараалал багасч, хэрэглэгчийн цаг хэмнэгдэж байна. Мөн ажилтнууд тооцоо хийх ажлаас тодорхой хэмжээгээр чөлөөлөгдөж, бараа байршуулах, агуулахын ажил, хэрэглэгчид зөвлөгөө өгөх зэрэг бусад ажилд илүү цаг гаргах боломж бүрдлээ.

Нэг дор олон хэрэглэгчид зэрэг үйлчлэх боломжтой болсноор салбарын үйлчилгээний хүчин чадал нэмэгдэж, үйл явц автоматжсанаар тооцооны алдаа, кассын зөрүү буурах ач холбогдолтой юм. Түүнчлэн орчин үеийн, технологид ээлтэй энэхүү үйлчилгээ нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, брэндийн дүр төрхийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

CU ECO FRIENDLY ЖИШИГ САЛБАР БОГДХАН УУЛАНД НЭЭГДЛЭЭ







CU Eco Friendly салбар нь үйлчлүүлэгчдийн өдөр тутмын хэрэгцээг ойроос, ая тухтай орчинд хангахаас гадна байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөцийг зөв зохистой ашиглах, хэрэглэгчдэд байгальд ээлтэй дадал хэвшүүлэх боломж бүрдүүлснээрээ онцлог юм. Тус салбарын интерьер, дизайн, тоног төхөөрөмжийн сонголтод эрчим хүч, усны хэрэглээг бууруулах, нөөцийг үр ашигтай ашиглах шийдлүүдийг тусгасан бөгөөд эрчим хүчний хэмнэлттэй хөргүүрийн хаалт, автомат гэрэлтүүлэг, ус хэмнэх мэдрэгчтэй системүүдийг хэрэгжүүлжээ. Түүнчлэн эдгээр шийдлийг CU-гийн 200 гаруй салбарт үе шаттайгаар нэвтрүүлээд байна. Eco Friendly концепт нь зөвхөн эрчим хүч, ус хэмнэхээс гадна тухайн орчны онцлог, хэрэглэгчдийн бодит хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг бий болгоход чиглэж байна.

Богдхан уулын энэхүү салбар нь ууланд алхахаар ирсэн иргэдэд шаардлагатай конвиниенс үйлчилгээг нэг дор хүргэхийн зэрэгцээ хүүхэдтэй хүмүүст зориулсан хүүхэд хуурайлах тусгай өрөөтэй CU-ийн анхны салбар болж байна.

СЭНТРАЛ КОММЕРС ХХК



Chinggis Dark Draft – “Дээд зэргийн амьд шар айргийг дэргэдээсээ”

Chinggis Dark Draft-ыг 2 литрийн савлагаатайгаар зах зээлд танилцуулж, найз нөхөд, гэр бүлийн хүрээнд хуваан хэрэглэхэд тохиромжтой сонголт болгон байршуулсан. Энэхүү шинэ форматыг онцлон харуулахын тулд бүтээгдэхүүний тусгай зураг авалт болон lifestyle төрлийн контентоор дамжуулан бүтээгдэхүүний онцлог, хэрэглээний мөчийг илэрхийлэн хүргэсэн.



Chinggis Beer x The HU “Wolf Totem”

Chinggis Beer брэнд THE HU хамтлагийн “Wolf Totem” тоглолтыг ивээн тэтгэж, брэндийн танигдалт, хэрэглэгчдийн оролцоог нэмэгдүүлэх олон талт идэвхжүүлэлт зохион байгуулсан. Хэвлэл мэдээлэл, сошиал медиа, тоглолтын талбайн брэндинг болон хэрэглэгчдэд зориулсан сонирхолтой үйл ажиллагаануудаар дамжуулан брэндийн үнэ цэнийг хүргэж, хэрэглэгчидтэй харилцах холбоог бэхжүүлсэн.




Kozel брэнд

Чехийн алдарт Kozel шар айргийн брэндийг Монголын зах зээлд албан ёсоор нэвтрүүлж, брэндийн танигдалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг таниулах зорилгоор маркетингийн цогц кампанит ажил хэрэгжүүлсэн. Хэвлэл мэдээлэл, сошиал медиа, контент бүтээгчидтэй хамтран ажиллаж, CU, E-mart зэрэг off-trade цэгүүдэд брэндинг, идэвхжүүлэлт зохион байгуулсан. Эдгээр ажлаар дамжуулан хэрэглэгчдэд Kozel брэндийн онцлог, хэрэглээний шинэ туршлагыг хүргэж, бүтээгдэхүүний туршилт болон борлуулалтыг дэмжсэн.

ЧИНГИС ШАР АЙРАГ ХХК







2026 оны 3-р улирлын байдлаар үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа хэвийн, тогтвортой явагдаж, үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг ханган ажиллалаа. Тайлант хугацаанд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд “Чингис Хар” шар айргийг 2 литрийн шинэ савлагаатайгаар үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлж эхэлсэн нь онцлох ажлуудын нэг байв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр өдөр тутмын хяналт, шаардлагатай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, тайлант хугацаанд ноцтой осол, ХАБ-ын зөрчилгүй ажилласан. Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх хүрээнд дотоод англи хэлний сургалтыг тогтмол зохион байгуулж, ажилтнуудын оролцоо болон сургалтын явц сайн үргэлжилсэн. Мөн үйлдвэрийн дотоод зохион байгуулалт, багийн хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо, сахилга хариуцлагыг сайжруулахад тогтмол анхаарч ажилласан. Нийтэд нь дүгнэхэд үйлдвэрийн үйлдвэрлэл, аюулгүй ажиллагаа, ажилтнуудын хөгжил болон өдөр тутмын үйл ажиллагаа тогтвортой хэрэгжсэн.

СЭНТРАЛ КОФЕ РӨУСТИНГ ХХК



Жуулчдад зориулсан “**Go Mongolia**” төслийг “Ara Festival”-д танилцуулж, зорилтот хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ хүргэх ажлыг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд жуулчид ихээр үйлчлүүлдэг CU-ийн 50 салбар, бэсрэг наадам зохион байгуулдаг жуулчны баазууд, Улсын Их Дэлгүүр, нисэх онгоцны буудал, Цонжин Болдог болон Тэрэлжийн жуулчны баазуудад бүтээгдэхүүнээ байршуулсан.



“**Your team deserves a better coffee break**” хөтөлбөрийн хүрээнд байгууллагын оффисын кофены хэрэглээнд Origin брэндийг таниулах, бүтээгдэхүүн болон үйлчилгээний шийдлүүдийг танилцуулах ажлуудыг хэрэгжүүлсэн. СЭМҮТ болон Mining Expo, HR Day, Барилга экспод оролцож, байгууллагын төлөөлөл, хүний нөөцийн мэргэжилтнүүд болон боломжит харилцагчдад брэндээ танилцуулсан.



“**Origin Mongolian Barista Championship 2026**” арга хэмжээг “Celebrating Mongolian Coffee” концепцийн хүрээнд зохион байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Энэхүү концепцоор бариста нар, кофе шопууд, кофе хуурагчид, брэндүүд болон кофенд дурлагчдыг нэгтгэж, Монголын кофены соёлыг хамтдаа бүтээж буй хүмүүс, байгууллагуудыг олон нийтэд таниулахыг зорьж байна.


СТОРА ЦЕНТРАЛ ХХК


Стора Централ ХХК 2026 онд хэрэглэгчдийн онлайн худалдан авалтын туршлагыг сайжруулах, захиалгын үйл явцыг илүү хурдан, хялбар болгох зорилгоор платформынхаа үндсэн функцуудыг шинэчиллээ.

Шинэчлэлийн хүрээнд хэрэглэгчид хамгийн өндөр эрэлттэй бүтээгдэхүүнүүдийг нэг дороос харах, мөн өмнөх худалдан авалтын түүхдээ үндэслэн хувь хүнд тохирсон бүтээгдэхүүний санал зөвлөмж авах боломжтой болсон. Үүний зэрэгцээ системийн интерфэйсийг илүү ойлгомжтой, хэрэглэгчдэд ээлтэй байдлаар шинэчилснээр бүтээгдэхүүн хайх, сонгох, захиалах үйл явцын үр ашиг, ашиглахад хялбар байдал мэдэгдэхүйц сайжирсан.

Хэрэглэгчдийн худалдан авах зардлыг бууруулах зорилгоор 2026 оны эхний улиралд АНУ-аас тээвэрлэгдэх ачааны хүргэлтийн үнийг 20%-иар бууруулж, БНХАУ-аас ирэх барааны тээврийг үнэ төлбөргүй хэвээр хадгалсан. Ингэснээр хэрэглэгчид өргөн сонголттой барааг илүү хэмнэлттэй нөхцөлөөр захиалах боломжийг үргэлжлүүлэн бүрдүүлэв.

Мөн 12 Стора боксын багтаамжийг нэмэгдүүлснээр том оврын барааг Стора агуулахад очих шаардлагагүйгээр өөрт ойр байрлах CU салбараас хүлээн авах боломжтой болсон нь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн цаг хугацаа, зардлыг хэмнэхэд дэмжлэг үзүүлэв.





НЭГТГЭСЭН ОРЛОГО, УР ДҮНГИЙН ТОВЧ ТАЙЛАН

/Сая төгрөгөөр/	2024 оны 9-р сарын 30	2025 оны 9-р сарын 30	2026 оны 9-р сарын 30
Нийт цэвэр борлуулалт	433,958.0	587,084.3	725,700.1
Борлуулалтын өртөг	353,033.7	474,149.1	585,808.5
Нийт ашиг (алдагдал)	80,924.3	112,935.2	139,891.6
Нийт ашгийн хувь	*18.6%*	*19.2%*	*19.3%*
Үйл ажиллагааны зардал	17,303.7	36,550.4	42,603.6
ХТЭХӨ Ашиг	63,620.6	76,384.8	97,288.0
ХТЭХӨ Ашгийн хувь	*14.7%*	*13.0%*	*13.4%*
Элэгдэл хорогдол	*24,429.3*	*33,487.2*	*45,120.1*
Мөнгөн бус зүйлс — олз (гарз)	*2,159.0*	*2,679.0*	*1,205.8*
ХТӨ Ашиг	*41,350.3*	*45,576.6*	*53,373.7*
Санхүүжилтийн зардал	*14,417.8*	*16,417.5*	*25,348.7*
Татварын өмнөх ашиг (алдагдал)	*26,932.5*	*29,159.1*	*28,025.0*
Татварын өгөөж (зардал)	*582.2*	*2,766.9*	*3,025.4*
Цэвэр ашиг (алдагдал)	**26,350.3**	**26,392.2**	**24,999.6**
Цэвэр ашгийн (алдагдлын) хувь	*6.1%*	*4.5%*	*3.4%*

Тайлбар: (1) Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт
(2) Харьцуулалт хийх зорилгоор 2024 оны 3-р улирлын дүн дээр Бизнес нэгдлээс үүссэн нэг удаагийн 19.4 тэрбум төгрөгийн олз цэвэрлэж харуулсан болно.

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Сая төгрөгөөр)	2024 оны 9-р сарын 30	2025 оны 9-р сарын 30	2026 оны 9-р сарын 30
Эргэлтийн хөрөнгө	**70,332.3**	**116,783.4**	**151,286.1**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,227.5	10,258.6	22,080.5
Дансны авлага	4,126.4	9,106.7	24,153.2
Бараа материал	40,764.9	70,768.7	66,532.5
Бусад эргэлтийн хөрөнгө	16,213.5	26,649.5	38,519.9
Эргэлтийн бус хөрөнгө	**192,601.0**	**291,746.0**	**393,730.7**
Биет болон биет бус хөрөнгө	122,028.8	200,825.5	255,298.7
Ашиглах эрхтэй хөрөнгө	52,483.6	73,826.6	98,590.7
Бусад эргэлтийн бус хөрөнгө	18,088.6	17,093.9	39,841.4
НИЙТ ХӨРӨНГӨ	**262,933.3**	**408,529.5**	**545,016.9**
Богино хугацаат өр төлбөр	**78,076.5**	**125,901.8**	**230,169.7**
Дансны өглөг	60,732.8	92,423.2	126,014.1
Богино хугацаат зээл	5,509.2	19,435.0	64,759.3
Бусад богино хугацаат өр төлбөр	11,834.5	14,043.7	39,396.3
Урт хугацаат өр төлбөр	**107,385.7**	**151,505.3**	**180,068.0**
Урт хугацаат зээл	33,974.1	54,204.8	85,044.5
Бусад урт хугацаат өр төлбөр	73,411.6	97,300.5	95,023.5
Эздийн өмч	**77,471.1**	**131,122.3**	**134,779.2**
Энгийн хувьцаа	111,425.2	111,425.2	111,425.2
Халаасны хувьцаа	-	-	(7,636.0)
Нэмж төлөгдсөн капитал	45,757.9	45,757.9	28,272.9
Эздийн өмчийн бусад хэсэг	318.7	318.7	318.7
Хяналтын бус хувь оролцоо	3,803.8	15,870.3	20,962.1
Хуримтлагдсан ашиг	(83,834.5)	(42,249.8)	(18,563.9)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**262,933.3**	**408,529.5**	**545,016.9**

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Сая төгрөгөөр/	2024 оны 9-р сарын 30	2025 оны 9-р сарын 30	2026 оны 9-р сарын 30
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	503,436.3	672,962.0	816,493.3
Мөнгөн зарлагын дүн (-)	(455,919.3)	(609,059.1)	(717,869.8)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**47,517.0**	**63,902.9**	**98,623.5**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	894.2	1,195.8	2,738.0
Мөнгөн зарлагын дүн (-)	(23,676.9)	(69,946.2)	(100,445.3)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(22,782.7)**	**(68,750.3)**	**(97,707.3)**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	46,481.1	417,972.8	398,777.3
Мөнгөн зарлагын дүн (-)	(64,877.1)	(413,166.5)	(399,143.9)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(18,396.0)**	**4,806.3**	**(366.6)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү	(91.5)	(131.8)	(201.0)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**6,246.9**	**(172.9)**	**348.6**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**2,980.6**	**10,431.5**	**21,731.9**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**9,227.5**	**10,258.6**	**22,080.5**

Хувьцааны ханшийн хөдөлгөөн


ПРЕМИУМ НЭКСУС ХК (CUMN):

2026 оны 9-р сарын 30-ний өдрийн байдлаар:

₮304.09

2026 оны нээлтийн ханш: 315.00
Нийт гаргасан хувьцаа: 1,114,252,034
Хаалтын ханш: 304.09

Эргэлтэд гаргасан хувьцаа: 1,114,252,034
52 долоо хоногийн хэлбэлзэл: 185.01 - 335.00
Зах зээлийн үнэлгээ: 338.8 тэрбум төгрөг



Анхаарал хандуулсанд баярлалаа

Холбоо барих:
И-мэйл: investor@cumongol.mn